



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 320

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх заалт, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Засгийн газрын 2020 оны 123 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.3, 4.9 дэх заалт, Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 168 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хүрээнд бий болсон "Ус хангамж, ариутгах татуургын байгууламж /багц2/-ийн нийт 33,984,050,195.03 (гучин гурван тэрбум есөн зуун наян дөрвөн сая тавин мянга нэг зуун ерэн таван төгрөг гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Замын-Үүдийн дэд бүтцийн ашиглалтын өмнөх захиргааны данс бүртгэлээс хасаж, Дорноговь аймгийн өмч ("Чандмань-Бадрал" орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани)-д бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Дорноговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга У.Баярбилэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг данснаас хасах, ашигласан хугацаанд ногдох элэгдэл хороодлын шимтгэлийг тооцож бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан хөрөнгийг орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, данс бүртгэлд тусгах, хүлээлцэх ажлыг зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу няглан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛВАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

D.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн
320 дугаар тогтоолын хавсралт

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ӨМЧ ("ЧАНДМАНЬ-БАДРАЛ" ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ)-Д БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Үндсэн хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нийт үнэ (төгрөг) |
|-----|---|-------------|------------|---|
| 1 | Ус цэвэршүүлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж | багц | 1 | 21,046,339,374.20 |
| 2 | Бохир ус цэвэршүүлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж | багц | 1 | 7,932,406,166.39 |
| 3 | Гүнийн худаг болон цэвэр усны шугам сүлжээ | багц | 1 | 3,708,732,850.16 |
| 4 | Цэвэр усны өргөлтийн насос станц | багц | 1 | 788,747,056.12 |
| 5 | Чөлөөт бус бохир усны өргөлтийн насос станц | багц | 1 | 507,824,748.17 |
| | Нийт дүн | | | 33,984,050,195.03 (гучин гурван тэрбум есөн зуун наян дөрвөн сая тавин мянга нэг зуун өрэн таван төгрөг гурван мөнгө) |